

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</i>	2022 оны 2-р улирал (2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр)
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	Ард Кредит ББСБ ХК, 9010002003, ADB, +976 77003322
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын Хөрөнгийн Бирж
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Банк бус санхүүгийн байгууллага
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	280,000,0000 (Хоёр зуун наян сая) ширхэг
<i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	СМ Д.ЛХАГВА-ОЧИР ЕНБ Х.ЦЭРЭННАДМИД
1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>
	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>
	Нийт актив 71.7 тэрбум төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 70.0 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 1.7 тэрбум төгрөг байна.
	<i>Орлогын тайлан</i>
	Хүүгийн орлого 5.7 тэрбум, хүүгийн зардал 3.2 тэрбум, хүүгийн бус орлого 2.4 тэрбум, хүүгийн бус зардал 3.3 тэрбум төгрөг, зээлийн эрсдэлийн сангийн зардал 836 сая төгрөг, татварын дараах цэвэр ашиг 662 сая төгрөг гарсан.
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>
	Богино хугацаат хөрөнгө оруулалтын багцад байршиж буй арилжааны үнэт цаасны зах зээлийн ханш буурч, 2021 оны цэвэр ашгаас 1.26 тэрбум төгрөгийг ногдол ашигт хуваарилсантай холбоотойгоор эздийн өмч 19.8 тэрбум төгрөг болсон байна.
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5.3 тэрбум төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст 6.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>

	2022 оны 06 сарын 20-ны өдөр болсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлаар компанийн хагас жилийн хүлээгдэж буй үр дүнг хэлэлцэж 7 дугаар сард компанийн хагас жилийн тайлангийн гүйцэтгэлийг танилцуулахаар шийдвэрлэсэн болно.	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	2022 оны 2-р улирлын байдлаар, Ард Кредит ББСБ ХК нь 662 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд цэвэр ашгийн маржин 8.1 хувь байна.
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Тайлант хугацаанд компани нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь 13.5%-тай байна.
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Дэлхий дахинд инфляци нэмэгдэж, макро түвшинд эдийн засаг хүндэрсэнтэй холбогдуулан зээл олголтыг тодорхой түвшинд бууруулж, эрсдэлийг зохистой түвшинд барихын зэрэгцээ компанийн үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой байлгахад анхаарч ажиллалаа. Нөгөө талаар тайлант хугацаанд харилцагчийн санхүүгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хэрэглээний зээлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхээр судалгааны шатанд ажиллаж эхэллээ. Монголбанкны бодлогын хүү 9%-иас нэг нэгж хувиар нэмэгдэж 10%-д хүрсэн ч зээлийн хүүгээ одоогоор нэмэгдүүлээгүй байгаа юм.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Эрсдэлийн сангаас хаасан нийт зээл 1.2 тэрбум төгрөг байна.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	<ol style="list-style-type: none"> 1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-тай хийсэн бонд буцаан худалдах гэрээ Гацуурт ХХК-ийн 2.2 тэрбум төгрөгийн дүнтэй бондыг буцаан худалдсан. Огноо: 2022.06.06 2. Ард Бит ХХК-тай байгуулсан авлагын гэрээ 50.0 сая төгрөгийг 6 сарын хугацаатай жилийн 22 хувийн хүүтэйгээр авлага үүсгэн шилжүүлсэн. Огноо: 2022.04.29 	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Тус тайлангийн хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.	
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Тус тайлангийн хугацаанд Ард Кредит ББСБ ХК (РД:5459567) -ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь 2022 оны 06 сарын 20-ны өдөр ээлжит бус хурал зохион байгуулагдсан. Уг хурлаар компанийн 2022 оны төсвийн тодотгол болон Компанийн засаглалын кодекстэй	

	<p>холбоотой асуудал хэлэлцсэн бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг нь өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг хэлэлцэж үүрэгт ажлаас чөлөөлсөн. Тус хуралд оролцсон нийт гишүүдийн саналаар Чулууны Ганзоригийг Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар сонгосон болно.</p>
7.	<p><i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i></p>
	<ol style="list-style-type: none"> 1. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь 9-өөс 11 гишүүнтэй байхаар заасан нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасан “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэсэн шаардлагад нийцсэн байна. 2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 4-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлаар Компанийн дүрмийг өөрчилсөнтэй холбоотойгоор ТУЗ-ийн (9) гишүүнийг томилсон байна. 3. ТУЗ-ийн бүх гишүүд нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдаж зохих ёсоор гэрчилгээ авсан байгаа нь Компанийн тухай хууль болон Компанийн Засаглалын Кодекс (“КЗК”) - т, түүнчлэн СЗХ-ны 2016 оны 3-р сарын 11-ны өдрийн 71 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.14.2-т заасан шаардлагад нийцсэн байна. 4. Эрх бүхий албан тушаалтнууд Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль, холбогдох журамд заасан эрх бүхий албан тушаалтуудад тавигддаг нийтлэг шаардлагуудыг хангасан байна. 5. Компани нь итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагын хувьд “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.14.1 дэх хэсэгт заасны дагуу 1 буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байхыг шаарддаг бөгөөд Компанийн ТУЗ-ийн бүтэц зохион байгуулалт нь журмын дээрх шаардлагад бүрэн нийцэж байна. 6. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасан аудитын хорооны даргыг ТУЗ-ийн хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан байна. 7. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь хэсэгт заасны дагуу Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах гүйцэтгэх удирдлагыг томилох бөгөөд Компанийн Гүйцэтгэх захирлаар 2020 оны 1-р сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн 2020/3 тоот тогтоолоор Гэрэлт овогтой Тэлмэнг томилсныг 2020 оны 2 сарын 11-ний өдөр ХЭУБ-т бүртгүүлэн, Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэсэн ба Компанийн хуулийн дагуу өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна. 8. Компанийн дүрмийн төсөл нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан заавал тусгах зүйлсийг бүрэн тусгасан байх бөгөөд агуулгын хувьд хууль тогтоомжид нийцсэн байна. 9. СЗХ-оос 2014 оны 5-р сарын 7-ны өдөр 162 дугаар тогтоолоор КЗК-ийг шинэчлэн баталж, Монголын хөрөнгийн биржийн А самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниуд энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллах, бусад хувьцаат компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаараа тайлбарлаж ажиллахыг үүрэг болгосон. Компанийн дүрэм болон холбогдох дотоод журмууд нь КЗК-ийн зарчимд бүрэн нийцсэн байна. 10. Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийн дагуу их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтгэйгээр гаргахаар мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-т сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй зөвлөлийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар гаргахаар заасан байдаг ба Компани нь хуульд заасан шаардлагын дагуу зохих ёсны дагуу хэлцлүүдээ ТУЗ-ийн хурлаар

хэлэлцүүлж батлуулсан байгаа нь Компанийн тухай хууль болон КЗК-ийн шаардлагад нийцсэн байна.

“Сноу Хилл Консалтанси” ХХН нь СЗХ-ны 2014 оны 1-р сарын 29-ний өдрийн 24 тоот тогтоол болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1. дэх хэсэгт заасны дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувьд энэхүү дүгнэлтийг гаргах эрхтэй.
/2021 оны 08 сарын 20-ны өдөр/

2022 оны II улиралд Компанийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэлд өөрчлөлт ороогүй болно.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Гэрэлт овогтой Тэлмэн

Албан тушаал: “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Халтар овогтой Цэрэннадмид

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

Овог, нэр: Давааням овогтой Лхагва-Очир

Албан тушаал: Санхүүгийн менежер

Гарын үсэг: